




Арилжааны мэдээ


- 2018 оны 18 дахь долоо хоногт Монголын хөрөнгийн биржээр нийт 899.13 сая төгрөгийн үнэт цаасны арилжаа явагдаж, зах зээлийн үнэлгээ 2.46 их наяд төгрөгт хүрлээ.
- Тус долоо хоногт MSE Топ-20 индекс 1.32% буурч 19,882.54 нэгжид хүрсэн бол MSE I индекс 0.28% буурч 9,745.69 нэгж, MSE II индекс 0.15% өсч 9,906.61 нэгжид тус тус хүрлээ.
- Нийт 50 компанийн 4,132,148 ширхэг хувьцаа 899,136,639.00 төгрөгөөр арилжаалагдсан байна.
- Хамгийн их өсөлттэй хувьцаагаар Усжуулах (CMD) 32.25% өсч 330.62 төгрөг, Талын гал (TAL) 15.00% өсч 15.87 төгрөгт тус тус хүрч хаагдлаа.
- Хамгийн их бууралттай хувьцаагаар Ногоон хөгжил үндэсний нэгдэл (JLT) 33.12% буурч 160.5 төгрөг, Блюскай секьюритиз (BSKY) 14.85% буурч 1,800 төгрөгт хүрч хаагдлаа.

MSE Топ 20 индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн

Монгол банкны USD/MNT ерөнхий харьцаа



Эх сурвалж: Монгол Банк

| | USD/MNT ханш | % Өөрчлөлт |
|-----|--------------|------------|
| USD | 2,402.49 | 0.04 |

Тодруулга

Энэхүү арилжааны мэдээ нь зөвхөн арилжааны болон санхүүгийн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Энэхүү мэдээнд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “БиДиСек ҮЦК” ХК хариуцлага хүлээхгүй болно.

Дараах link-ээр орж арилжааг харна уу: <http://bdsec.mn/trade/>

Зах зээлийн өөрчлөлт

| Индекс | Нэгж | % Өөрчлөлт |
|-------------------|-----------|------------|
| MSE Топ-20 индекс | 19,882.54 | -1.32% |
| MSE I индекс | 9,745.69 | -1.28% |
| MSE II индекс | 9,906.61 | 0.15% |

| Зах зээлийн хураангуй | Нийт (MNT) |
|-----------------------|-------------------|
| Зах зээлийн үнэлгээ | 2,468,077,730,381 |
| Арилжигдсан үнийн дүн | 899,136,639 |

| Үнийн дүнгээр | Хаалт (MNT) | Мөнгөн дүн |
|---------------|-------------|-------------|
| ЛэндМН ББСБ | 46,55 | 147,841,600 |
| ЖИНСТ-УВС | 1,598 | 100,277,667 |
| ГОВЬ | 22,000 | 84,416,460 |
| АПУ | 625.01 | 66,392,445 |
| ТАВАНТОЛГОЙ | 10,450 | 64,327,150 |

| Тоо ширхэгээр | Хаалт (MNT) | Нийт |
|----------------|-------------|-----------|
| ЛэндМН ББСБ | 46.55 | 3,325,091 |
| РЕМИКОН | 48.00 | 188,776 |
| ЖЕНКО ТУР БЮРО | 90.05 | 147,007 |
| АПУ | 625.01 | 105,304 |
| МЕРИКС | 30.00 | 83,041 |

| Ханш өссөн | Хаалт (MNT) | % Өөрчлөлт |
|----------------------|-------------|------------|
| УСЖУУЛАХ | 330.62 | 32.25 |
| ТАЛЫН ГАЛ | 15.87 | 15.00 |
| ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА | 9,305 | 14.95 |
| ИХ БАРИЛГА | 3,700 | 12.12 |
| МОНГОЛ САВХИ | 850 | 8.70 |

| Ханш буурсан | Хаалт (MNT) | % Өөрчлөлт |
|-----------------------------------|-------------|------------|
| НОГООН ХӨГЖИЛ ҮНЭДСЭНИЙ НЭГДЭЛ | 160.5 | 33.12 |
| БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ | 1,800 | 14.85 |
| МЕРИКС | 30.00 | 9.09 |
| МОНГОЛ НЭХМЭЛ | 3,004 | 7.57 |
| МИК ХОЛДИНГ | 10,510 | 6.58 |

| ЗЗҮнэлгээ өндөр | Хаалт (MNT) | Тэрбум/₮ |
|-----------------|-------------|----------|
| АПУ | 625.01 | 665.12 |
| ТАВАН ТОЛГОЙ | 10,450 | 550.35 |
| МИК ХОЛДИНГ | 10,510 | 217.65 |
| ГОВЬ | 22,000 | 171.62 |
| СҮҮ | 218.00 | 74.99 |



ЭНЭ ДОЛОО ХОНОГТ

МОНГОЛ БАЗАЛЫТ ХААЛТТАЙ ХК НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛНО. (frc.mn)

- “Санхүүгийн зохицуулах хорооны ээлжит хуралдаанаар “Монгол Базальт” хаалттай ХК нь нээлттэй хувьцаат компани болон өөрчлөн зохион байгуулагдсантай холбогдуулан тус компанийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 56.4 сая ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэж, тогтоол гаргалаа. Үүний 30 хувь буюу 16.9 сая ширхэг хувьцааг тус бүрийг 380 төгрөгийн тогтоосон үнээр нийтэд санал болгон худалдахыг “Монгол Базальт” ХК-д зөвшөөрөсөн байна. Гэхдээ нийтэд санал болгон худалдаалах хувьцааг зах зээлд 100 хувь арилжаалсан тохиолдолд үнэт цаасыг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагаа амжилттай болсонд тооцно. Иймд анхдагч зах зээлийн арилжааг хариуцлагатайгаар зохион байгуулахыг үнэт цаас гаргагч болон андеррайтингийн ба бусад үйлчилгээ үзүүлэгч нарт даалгажээ.

САЙНШАНДЫН САЛХИН ПАРКИЙН ЭХНИЙ

ТУРБИНЫГ АМЖИЛТТАЙ БОСГОЛОО. (bloombergtv.mn)

- Сайншандын салхин паркийн анхны салхин турбины угсралт амжилттай боллоо. 55 мегаватт суурилагдсан хүчин чадалтай энэхүү салхин парк энэ оны 11 дүгээр сард ашиглалтад орно гэдгийг “Сайншанд салхин парк” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Оливер Шнорр хэлж байсан юм. Нийт 24 турбиныг босгохоор төлөвлөсөн байна. Энэхүү төслийн дүнд 120 сая ам.долларын шууд хөрөнгө оруулалт хийгдэж байгаа бөгөөд барилгын ажлын оргил үед 500 ажлын байр бий болох ажээ. Харин ашиглалтад орсны дараа 30-40 хүнийг байнгын ажлын байраар хангах юм байна. “Сайншанд салхин парк” компанийн удирдлагын мэдээлснээр 100 мянган өрхийг эрчим хүчээр хангах чадалтай учир ойролцоогоор 200 мянган тонн нүүрс хүчлийн хийг агаар мандалд ялгарахаас сэргийлэх юм. Өнгөрсөн сард Эрчим хүчний яамны удирдлагууд 55 мегаваттын Сайншандын салхин паркийн бүтээн байгуулалттай танилцаж, төлөвлөгөөний дагуу үргэлжилж байна гэж дүгнэжээ. Сайншандын төсөл болон энэ онд төлөвлөсөн нарны эрчим хүчний төслүүд амжилттай хэрэгжсэнээр Засгийн газрын нийт эрчим хүчний 20 хувийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах зорилт 2019 он гэхэд биелэхээр байгааг зохицуулах хорооноос мэдээлж байсан юм.

ХААБ: БОЛОВСРУУЛААГҮЙ ЦАЙВАР НООЛУУРЫН ҮНЭ 4.7 ХУВИАР БУУРЛАА. (bloombergtv.mn)

- Хөдөө аж ахуйн биржид голлох түүхий эдийн үнэ буурах хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, боловсруулаагүй бараан ноолуурын үнэ пүрэв гарагт гурван хувиар буурч, 97 мянган төгрөг болжээ. Харин урт хугацаанд авч үзвэл ханш нь өмнөх оны мөн үеэс 14.3 хувиар өндөр байгаа юм. Түүнчлэн боловсруулаагүй цайвар ноолуурын үнэ 4.7 хувиар буурч, 102 мянган төгрөг болсон байна. Энэ нь мөн жилийн дүнгээр 17.9 хувиар өссөн дүн болжээ. Дөрөвдүгээр сар гарснаас хойш Хөдөө аж ахуйн биржид нийт 140.1 тэрбум төгрөгийн түүхий эд арилжаад байна. Өөрөөр хэлбэл арилжааны жилийн өмнөхөөс 12.2 тэрбум төгрөгөөр өсөөд байгаа аж.

“ТАЛХ ЧИХЭР” ХК ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ “ISO 22 000” СТАНДАРТ НЭВТРҮҮЛЛЭЭ (montsame.mn)

- “Хүнсний манлай үйлдвэр “Талх Чихэр” ХК хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны “ISO 22 000” стандартыг нэвтрүүлжээ.
- 2005 оноос дэлхийн зах зээлд хэрэгжиж эхэлсэн уг стандартыг “Талх чихэр” ХК Монгол Улсын хүнсний салбарт анх удаа хэрэгжүүлж буйгаараа онцлогтой юм. Эдүгээ дэлхийн 200 гаруй улс “ISO 22 000” удирдлагын тогтолцооны стандартыг нэвтрүүлжээ.
- “Талх Чихэр” ХК-ийн ерөнхий менежер С.Тамираа ярихдаа, Манай компани нийслэлийн хэрэгцээний талх гурилан бүтээгдэхүүний 60 гаруй хувийг хангаж байна. хэрэглэгчид ямар нэгэн эрсдэлгүй, чанартай, найдвартай, бүтээгдэхүүн хэрэглэж, сэтгэл хангалуун үйлчлүүлэх боломжийг олгох үүднээс бид үйл ажиллагаандаа дээрх стандартыг нэвтрүүлж буй юм. Түүнчлэн манай компани 100 гаруй нэр төрлийн түүхий эдийг бэлтгэн нийлүүлэгчдээс авдаг. Тиймээс энэхүү стандартыг нэвтрүүлснээр бэлтгэн нийлүүлэгчдийн үйл ажиллагаа чанаржиж, тэдэнд хяналт, шаардлага тавих боломж бүрдэж байгаагаараа энэхүү стандартын ач холбогдол оршиж байгаа юм.
- Тус компани 2004 оноос инновацийн бодлогыг амжилттай хэрэгжүүлж, хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлжээ

“ТӨРИЙН ӨМЧИЙН МЕНЕЖМЕНТ БА НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА 2018” ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА (mse.mn)

- Монгол Улсын Засгийн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохион байгуулсан төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, засаглал, нийгмийн хариуцлагыг олон нийтэд сурталчлах зорилго бүхий “Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага-2018” өдөрлөг 2018 оны 5 дугаар сарын 3-ны өдөр Сүхбаатарын талбай дээр зохион байгуулагдлаа.
- Энэхүү өдөрлөгт “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК, “Арилжаа төлбөр тооцоо” ХХК оролцож олон нийтэд хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааны талаар болон арилжаанд хэрхэн оролцож хөрөнгө оруулалт хийх, хувьцаат болон гишүүн компанийн үйл ажиллагаа зэрэг үнэт цаасны зах зээлийн талаарх зөвлөгөө, мэдээллийг хүргэжээ.

МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ “В” ХЭВЭЭР ҮЛДЭЭХ ШИЙДВЭР ГАРАВ

- Стандарт энд Пүүрс агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг “В” хэвээр үлдээх шийдвэр гаргажээ. Тус агентлагаас Монгол Улсын урт хугацааны зээлжих зэрэглэлийн үнэлгээг хэвээр үлдээхэд төсвийн тэнцэлд түүхий эдийн үнийн өсөлт эерэгээр нөлөөлж, сүүлийн 12 сарын хугацаанд төсвийн зарцуулалт илүү хатуу хяналттай байсан боловч Монгол Улсын төсвийн санхүүжилт эмзэг хэвээр байгааг онцолжээ.



“БиДиСЕК ҮЦК” ХК

Андеррайтер, Брокер

Хөрөнгө оруулалтын зөвлөх

Арилжааны мэдээ
18 дахь долоо хоног, 2018

О.Уранбайгал

Харилцагчийн албаны менежер
И-мэйл: baigal@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1
8-р хороо, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар, Монгол улс
Утас: 976-11-313108
Факс: 976-11-321763

Б.Билгүүн

Харилцагчийн алба,
мэргэжилтэн
И-мэйл: bilguun@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1
8-р хороо, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар, Монгол улс
Утас: 976-11-313108
Факс: 976-11-321763

Э.Алтансүх

Харилцагчийн алба,
мэргэжилтэн
И-мэйл: darkhan@bdsec.mn

БиДиСек Дархан

Дархан-Уул аймаг, Монгол улс
Утас: +976-94082846

Энэхүү арилжааны мэдээ нь зөвхөн арилжааны болон санхүүгийн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Энэхүү мэдээнд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “БиДиСек ҮЦК” ХК хариуцлага хүлээхгүй болно.